

БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Б.Баянжаргал
ДХИС-ийн Удирдлагын академийн
магистрант, хошууч

Товч агуулга: Байгууллагын үйл ажиллагааны хяналтын тухай асуудал гүйцэтгэлийн төлөвлөгөө хийхээс эхлээд гүйцэтгэлийг дүгнэх хүртэл анхаарал татсан асуудлын нэг болж байна. Төрөөс байгууллагын үйл ажиллагааг хянах, төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд хяналтын тогтолцоог хэрэгжүүлснээр, үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах үндэс тавигдана. Иймээс төрөөс хэрэгжүүлэх хяналтыг бизнесийн байгууллага, тэр дундаа барилгын салбарт хяналт хэрхэн явагдаж байгааг барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа бизнес эрхлэгчид, ажилчдаас судалгаа авч ерөнхий дүгнэлт хийсэн. Судалгаанд нийт 165 оролцогч хамрагдсан бөгөөд судалгааны боловсруулалтыг харьцуулан жиших, энгийн статистик боловсруулалтаар нэгтгэн дүгнэсэн.

Түлхүүр үгс: төр, хувийн хэвшил, хяналт, барилгын салбар.

Оршил

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт менежментийн хяналтыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

Төрийн үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үр дүнгийн хяналт сайжирсан байна;

Шинжлэх ухааны ололтод суурилсан судалгаа, шинжилгээний төвийг өргөжүүлж, шинжилгээ хийх нөхцөл байдлыг сайжруулан, хууль хяналтын байгууллагуудын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг хөгжүүлнэ гэж тусгагдсан нь энэхүү сэдвийг судлах үндэслэлийг тодорхойлсон.

Батлан хамгаалах байгууллагад “Улсын секторын санхүүгийн дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зарим асуудал” сэдэвт удирдахуйн ухааны докторын зэрэг горилсон бүтээлд санхүүгийн дотоод хяналтын тогтолцоог хэрхэн боловсронгуй болгох талаар дэлгэрэнгүй судалсан (Д.Авирмэд, 2011).

Бизнесийн удирдлагын докторын зэрэг горилсон Гаалийн хяналтын эрсдэлүүд, тэдгээрийг бууруулах зарим арга зам” сэдэвт бүтээлд, гаалийн байгууллагын хяналтад ямар эрсдэл үүсэж болзошгүй, тэдгээр эрсдэлийг хэрхэн бууруулах боломж байгааг судалсан (Д.Цэндсүрэн, 2015).

Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаанд уг асуудал зохих хэмжээнд хөндөгдсөн судлагдснаар ирсэн байна.

Доктор профессор Б.Чимид “...төрийн хяналт шалгалт нь хууль тогтоомжийн биелэлтийг хангахад шууд чиглэх олон түмний өргөн оролцоотойгоор, орон тооны аппаратын хүчээр, хууль зүйн талаар заоаглах бүрэн эрхийн үндсэн дээр хэрэгждэг. Төрийн хяналт шалгалт бол төрийн

байгууллагуудаас удирдлагын бүх чиглэлээр эрх зүйн хэм хэмжээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа хяналт шалгалт мөн...” гэж тодорхойлжээ.

Төрийн хяналт шалгалтын тодорхой төрлүүдийг судалсан судалгааны бүтээлүүд байдаг боловч төрийн хяналт шалгалтын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, цаашлаад барилгын салбар дахь эрх зүйн зохицуулалтын практикийг судлан тулгамдаж буй асуудлуудыг нээн илрүүлэх, түүнийг шийдвэрлэх эрх зүйн болон зохион байгуулалтын шинжтэй зарим арга хэмжээг санал болгоход чиглэгдэх нь анхаарал татсаар байна.

Нэг. Хяналт, төрийн болон байгууллагын хяналтын онол арга зүй

“Хяналт” гэдгийг Я.Цэвэлийн Монгол хэлний тайлбар тольд “...үйл үйлдэлд болгоомжтой хандах, магадлах “...хаширлан цэгцлэх...” гэж утгачилж тайлбарласан байна.

С.И.Ожегов Орос хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд “хяналт гэдэг нь субъект тогтолцооны үйлдэл, харицлааг ажиглах, анхаарал тавих, чиглүүлж нөлөөлөх...” гэсэн утгаар тайлж тодорхойлсон байна.

Хяналт нь тухайн нийгмийн харилцааны онцлогоос хамаарч янз бүрийн хэлбэртэй байдаг нь нийгмийн түүхэн хөгжлийн зүй тогтлоос урган гарсан зайлшгүй зүйл юм. Нийгмийн амьдралд хяналтын олон янзын хэлбэр тогттолцоо оршоор ирсэн.

Нийгмийн амьдралд оршиж ирсэн хяналтын, тогтолцоонд төрийн хяналт онцгой байр эзлэх бөгөөд энэхүү хяналтын онолын анхны үндэслэл нь МЭӨ V-IV зууны үеийн эртний Грекийн нэрт сэтгэгч Аристотель, Платон, Ромын нарт хуульч, сэтгэгч Цицерон нарын анхны боловрслуулсан шилдэг төрийн тухай сургаалаас их үндэстэй юм.

Төрийн хяналт шалгалт нь төрийн удирдлагын ба төрийн эрх барих үйл ажиллагааны нэг үндсэн арга төдийгүй салшгүй хэлбэр мөн. Энэ нь төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хүрээнд нэгэн зэрэг хэрэгжих хууль дээдлэх ёсны нэн чухал баталгаа болдог гэж үзэж болох юм. Төрийн хяналт шалгалт ямар түвшинд хэрэгжиж ямар үр дүнтэй хийгдэж байгаагаас төрийн бодлого, ашиг сонирхлын тогтвортой хийгээд халдашгүй байдал шууд хамаарч төр, иргэн, нийгмийн хоорондох харьцааны тэнцвэрт байдал хангагдана.

Аливаа төрийн хяналт нь тухайн улс орны нийгмийн харилцааны хөгжлийн түвшин чиг ханлдлагыг тусгасан байдаг. Төрийн хяналт нь төрт ёсны хөгжлийн нэг салшгүй үр дүн төдийгүй тэр улсын хууль тогтоомж хэрхэн хэрэгжиж байгаагийн баталгаа болдог.

Байгууллагад хяналтын зохистой тогтолцоо бүрдсэнээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт сайжрах, санхүү, хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, бүх шатны удирдлагад дэмжлэг үзүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг олон талт үр ашигтай байдал бий болдог. Түүнчлэн хяналтын зохистой тогтолцоо нь компанийн засаглалын голлох хэсгийн нэг учраас ямар салбарт үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран байгууллагууд хяналтын тогтолцоогоо зөв бүрдүүлэхэд зайлшгүй анхаарах шаардлага үүсдэг.

Байгууллагын зорилгыг хангахад саад болох эрсдэлийг зөвшөөрөх түвшинд хүртэл бууруулахад чиглэсэн хяналтын үйл ажиллагааг тодорхойлох; мэдээллийн технологиор ерөнхий хяналтуудыг хэрэгжүүлэх; дотоод хяналтын үйл ажиллагааг хяналтын бодлого, журмын дагуу хэрэгжүүлэх үйл явцыг хяналт гэнэ.

Хяналт нь байгууллагын зорилгыг жигд тасралтгүй хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлдэг үйл явц юм. Хяналтын үйл явцыг зөв зохион байгуулснаар аливаа нэг асуудал үүсэн томорч, шийдэгдэхгүй явсаар байгууллагын амжилтанд хор хохирол учруулах хэмжээнд хүртэл даамжрахаам сэргийлэх боломжтой. Хяналтыг амжилттай хэрэгжүүлсний үндсэн дээр байгууллагын болон хувь хүн нэг бүрийн үр бүтээлч үйл ажиллагааг дэмжин хөхүүлэх бололцоо бий болгодог.

Хяналтын үндсэн 5 үүрэг:

1. Тодорхойгүй байдлыг тодорхой болгох
2. Алдаа дутагдлыг илрүүлэх
3. Нөцөл боломжийг тогтоох
4. Хүнд бэрхшээлтэй нөхцөл байдлыг удирдах
5. Эрх мэдлийг бусдад шилжүүлэх

Судалгааны ажлын боловсруулалт


Энэхүү судалгаан ажлаар төр ба бизнесийн байгууллагын хамтын ажиллагаанд хэрхэн хяналт хийгдэж байгаа талаар судаллаа. Барилгын салбар дахь төрийн хяналт, шалгалтын эрх зүйн зохицуулалт хэрхэн явагдаж байгааг тандан судлалаа. Манай судалгаанд барилгын салбарт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг 28 аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, 165 оролцогч судалгаанд хамрагдлаа. Судалгаанд оролцогчдыг насны интервалаар нь авч үзвэл, манай барилгын салбарын төлөөлөл 29-35 болон 36-42 насныхан байгаа нь харагдаж байна. Залуу ажилчид байгууллагад түгээмэл байр суурьтай байх нь байгууллага хамт олны хувьд эрч хүчтэй, сурч хөгжих боломжтой, идэвхжүүлэлт хурдан хүрэх, шинэ санаачлага гаргах зэрэг давуу талтай ч нөгөө талаар мөн залуучуудыг сургаж авах зардал нь их байх талтай.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын насны ангилал

№	Насны ангилал	Тоо	Хувь
1	21-28 настай	58	35.15%
2	29-35 настай	45	27.27%
3	36-42 настай	25	15.15%
4	43-50 настай	22	13.33%
5	51 ээс дээш настай	15	9.09%
НИИТ		165	100%

График 1. Оролцогчдын боловсролын түвшин

Доктор
 Магистр
 Бакалавр
 Тусгай дунд
 Бүрэн дунд



Судалгааны үр дүнгээс харахад, доктор 5%, магистр 46%, бакалавр 39%, тусгай дунд-12%, бүрэн дунд-3% эзэлж байна. Барилгын салбарт ажиллаж байгаа ажилчдын тал хэсэг нь магистрын зэрэгтэй байгаа нь сүүлийн жилд ажиллаж буй барилгын салбарын ажилчдын тоо өссөнг илтгэж байна.

Судалгаанд оролцогчдын барилгын салбарт өөрийн техникийн ур чадварыг үнэлэх судалгааг авахад, бага, багавтар, дундаж, сайн, маш сайн гэсэн үндсэн 5 үнэлгээнд хариулт өгсөнгөөс, салбартаа өөрийгэ эдундажаас дээгүүр гэж үнэлсэн үнэлгээний ерөнхий төлөв харагдаж байна.

Хүснэгт 2. Барилгын салбарын техникийн ур чадвар

№	Техникийн ур чадвар	Хувь
1	3.92	19.74%
2	3.89	18.63%
3	3.68	21.90%
4	3.52	20.35%
5	3.50	19.35%
НИЙТ	18.51	100%

Барилгын салбарт ажиллаж байгаа ажилчдын хувьд ажил үйлчилгээг хийхэд шийдвэр гаргах шаардлага байнга тулгардаг.

Хүснэгт 3. Шийдвэр гаргах ур чадвар

№	Шийдвэр гаргах ур чадвар	Хувь
1	3.91	21.41%
2	3.71	20.31%
3	3.59	19.66%
4	3.53	19.33%
5	3.52	19.27%
НИЙТ	18.26	100%

Судалгаанд оролцсон оролцогчдоос барилгын салбарын төрийн хяналт, эрх зүйн зохицуулалт хэрхэн шударга явагддаг, ямар хэрэгцээ шаардлага байгааг анкетын асуулгын аргаар судалсанг асуумж болон хариултыг дараах байдлаар нэгтгэн харууллаа.

Хүснэгт 4. Барилгын салбарын ажилчдын сэтгэл ханамжийн судалгаа

№	Үнэлгээ өгсөн оролцогчдын тоо	Үнэлгээ					Нийт
		1	2	3	4	5	
1	Механик аюулгүй байдлыг хангах	55	23	41	11	35	165
2	Галын аюулгүй байдлыг хангах	42	23	28	35	37	165
3	Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах	22	29	38	41	35	165
4	Хүний аюулгүй байдлыг хангах	29	35	41	25	35	165
5	Барилга байгууламж ашиглагчдын аюулгүй байдлыг хангах	37	36	35	16	41	165
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах;	33	23	55	13	41	165
7	Барилгын үйл ажиллагаанд ногоон хөгжлийн бодлого, ногоон барилгын шаардлагыг хэрэгжүүлэх	12	39	41	28	45	165
8	Зураг төслийн дагуу баригдсан байх;	26	28	33	13	65	165
9	Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байх;	31	45	28	25	36	165
10	Байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх;	29	33	26	25	52	165
11	Зэргэлдээ орших барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулахгүй байх.	19	19	25	65	37	165
12	Харилцаа,холбооны хяналт	39	36	22	29	39	165

Барилгын салбарын ажилчдын сэтгэл ханамжийн судалгааг авахдаа, төрийн хяналт, эрх зүйн зохицуулалтад тусгагдсан шаардлагатай үзүүлэлт, ангилалаас авч оролцогчдоор үнэлүүлэн харьцуулсанг зарим инфограк дүрслэл /Хавсралт 1/-ээр харьцуулан судаллаа. Судалгааны үр дүнд манай оролцогчдын өгсөн үнэлгээнээс хүснэгт т дүрслэгдсэн зарим үзүүлэлт өндөр сэтгэл ханамжийг өгсөн байна гэж дүгнэх боломжтой.

Дүгнэлт


Монгол Улсын Засгийн газар 2022 оны эхнээс төрийн хяналт шалгалтыг багасгахыг үүрэг болгосон. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чиглэсэн

төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2022 оны нэгдүгээр сарын 1-нээс 50 хувиар бууруулах, зарим шаардлагагүй шалгалтуудыг цуцлахаар болсон. Мөн зөвхөн эрсдэлд суурилсан, зайлшгүй хийгдэх хяналт шалгалтыг төлөвлөж хэрэгжүүлэх, хяналт шалгалтыг цахим хэлбэрт шилжүүлэхээр болсон.


Барьж буй барилга нь эрчим хүч, ус зэргийг хэмнэсэн, саарал усыг ашигладаг бол уг барилгыг барьсан компанид сертификат /шошго/ олгож дараа дараагийн бүтээн байгуулалтад төлөх татвараас тодорхой хувь хэмжээгээр чөлөөлж болох юм.

Байгууллагын хяналтын үндсэн төрөлд тооцогдох урьдчилсан, явц дундын, төгсгөлийн хяналтыг бизнесийн болон төрийн байгууллагын бүх үйл ажиллагааны шатад хэрэгжүүлэх нь ажлын үр дүн, гүйцэтгэлд шууд нөлөөлнө гэж дүгнэж байна.

Хавсралт. 1. Инфографик дүрслэл



Хүний аюулгүй байдлыг хангах



Эх сурвалжийн жагсаалт

Долгорсүрэн.Ж “Захиргааны хяналт” УБ., 2005 он
 Долгорсүрэн.Ж “Монгол улсын захиргааны эрх зүй” УБ., 2008 он
 Эрдэнцогт.А “Монгол улсын захиргааны процессын эрх зүй” УБ 2006
 Дашцэрэн.Д “Монгол Улсын захирганы эрх зүй” УБ., 2003 он
 Таванжин.Д “Монгол улсын төрийн хяналт шалгалт УБ., 2000он
 Сосорбурам.Т, Өнөрбаяр.Э “Төрийн албаны тухай”7 эрх зүйн баримт
 бичгийн эмхтгэл/ УБ.,2011 он
 Эрдэнэбат.Д, Төрдалай.Р, Алтантөгс.Н “Монгол улсын төрийн хяналт
 шалгалтын байгууллагын түүх УБ 2012 он
 Чимид.Б “Төр, захиргааны эрх зүй” УБ 2006 он
 Бямбаатогтох.Ё “Төрийн хяналт шалгалт” УБ., 2005 он
 Цэвэл.Я ”Монгол хэлний тайлбар толь ” УБ, 2010 он
 Бурмаа.Н “Төрийн хяналт, хариуцлага” УБ 2018
 Удвал.Б “Төрийн хяналт, удирдлага” УБ., 2001 он
 Сүхбаатар.Ж” Өрнөдийн орнуудын захиргааны эрх зүйн тойм” УБ.,
 2005 он